

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Мөрөн сумын Цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2025/076/НА-СТА-ТШЗ

| | |
|-----------------------|---|
| Чингис хот 2025 он | Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн Стандарт дүгнэлт аудит ХХК аудитор: Б.Наранцэцэг Утас: 99569960 Цахим хаяг: info@sda-audit.mn |
|-----------------------|---|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12

E-mail: khentii@audit.gov.mn

2025.02.24 № 190

танай _____ -ны № _____ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН МӨРӨН СУМЫН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Д.ПҮРЭВЖАРГАЛ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Мөрөн сумын Цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр байна. Үүнд:

Хүнсний материалын үлдэгдэлд түүвэр тооллого хийхэд 439 кг буюу 5,487.5 мянган төгрөгийн мах дутагдсан, жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг чанартай, үнэн зөв явуулаагүй, санхүүгийн тайланд үлдэгдлийг зөв тусгаагүй зэрэг зөрчил нь Төрийн болон нутгийн өмчийн тухай хуулийн 71, 72, 73 дугаар зүйлд заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын оршин байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд улсын төсвөөс 370,214.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 36,110.1 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 520.0 мянган төгрөг, нийт 406,844.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 406,050.5 мянган төгрөг зарцуулан, 2,197.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, харилцах дансандаа 55,940.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар 5,897.6 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд, 1 төлбөрийн акт тогтоож, 1 албан шаардлага хүргүүлсэн.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

232520190

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 11 зорилтын хүрээнд 55 арга хэмжээ тусгагдаж, 100 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 130,083,245.19 | 133,908,287.63 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 55,216,593.31 | 55,940,485.75 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 55,216,593.31 | 55,940,485.75 |
| 3121 | Төгрөг | 55,216,593.31 | 55,940,485.75 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 55,216,593.31 | 55,940,485.75 |
| 33 | АВЛАГА | 410,127.52 | 410,127.52 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 410,127.52 | 410,127.52 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 74,456,524.36 | 77,557,674.36 |
| 351 | Түүхий эд материал | - | 81,000.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | - | 81,000.00 |
| 354 | Хангамжийн материал | 74,456,524.36 | 77,476,674.36 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,188,265.00 | 3,257,565.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 554,800.00 | 764,800.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 853,500.00 | 1,295,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 6,712,250.00 | 6,149,600.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 64,147,709.36 | 66,009,709.36 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 459,563,827.65 | 450,525,183.14 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 459,563,827.65 | 450,525,183.14 |
| 392 | Биет хөрөнгө | 452,291,827.65 | 443,253,183.14 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 480,361,990.07 | 480,361,990.07 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (51,927,305.19) | (57,790,036.77) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 49,939,214.25 | 50,889,214.25 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (32,161,690.46) | (34,887,039.29) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 18,569,184.56 | 18,569,184.56 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (13,851,455.48) | (14,893,870.10) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 8,725,480.00 | 8,725,480.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (7,363,590.10) | (7,721,739.58) |
| 393 | Биет бус хөрөнгө | 7,272,000.00 | 7,272,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 7,272,000.00 | 7,272,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 589,647,072.84 | 584,433,470.77 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 2,700.03 | 0.03 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 2,700.03 | 0.03 |
| 413 | Өглөг | 2,700.03 | 0.03 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 2,700.03 | 0.03 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 589,644,372.81 | 584,433,470.74 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 589,644,372.81 | 584,433,470.74 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 27,787,083.00 | 27,787,083.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 27,787,083.00 | 27,787,083.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 525,183,607.29 | 519,972,705.22 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 525,183,607.29 | 525,183,607.29 |
| 51220 | Тайланг үеийн үр дүн | - | (5,210,902.07) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 36,673,682.52 | 36,673,682.52 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 589,647,072.84 | 584,433,470.77 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1) | 324,246,200.00 | 407,724,400.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | - | 1,400,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | - | 1,400,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | 450,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 450,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого үндсэн хөрөнгө | - | 950,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 324,246,200.00 | 406,324,400.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 297,818,700.00 | 370,214,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 297,818,700.00 | 370,214,300.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 26,427,500.00 | 36,110,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 26,427,500.00 | 36,110,100.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 290,042,414.59 | 412,935,302.07 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 290,042,414.59 | 412,935,302.07 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 289,990,094.93 | 410,737,980.22 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 186,278,325.35 | 287,122,037.10 |
| 210101 | Үндсэн цалин | 186,278,325.35 | 185,130,117.99 |
| 210102 | Нэмэгдэл | - | 90,980,577.35 |
| 210104 | Урамшуулал | - | 11,011,341.76 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 23,659,181.07 | 35,303,963.46 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,049,120.93 | 24,688,298.75 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,415,164.14 | 2,689,746.09 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,178,865.25 | 1,453,293.12 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 272,912.84 | 1,572,955.99 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,743,117.91 | 4,899,669.51 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 24,975,180.34 | 31,912,778.15 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,478,168.30 | 4,214,098.15 |
| 210302 | Тулш, халаалт | 20,348,000.00 | 26,315,680.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,149,012.04 | 1,383,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 2,083,850.00 | 1,664,500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 625,500.00 | 37,000.00 |
| 210402 | Гээвэр, шатахуун | 228,600.00 | - |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 1,229,750.00 | 1,627,500.00 |
| 2105 | Нормативт зардал | 27,219,650.00 | 29,845,700.00 |
| 210502 | Хоол, хүнс | 27,219,650.00 | 29,845,700.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,413,500.00 | 2,169,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,413,500.00 | 2,169,500.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 539,000.00 | 1,394,557.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 539,000.00 | 1,394,557.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 22,821,408.17 | 21,324,944.51 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,786,660.03 | 9,304,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,162,100.00 | 2,032,300.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 18,872,648.14 | 9,988,644.51 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 52,319.66 | 2,197,321.85 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 52,319.66 | 2,197,321.85 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 52,319.66 | 2,197,321.85 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 34,203,785.41 | (5,210,902.07) |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 34,203,785.41 | (5,210,902.07) |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 324,246,200.00 | 406,774,400.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | - | 450,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | - | 450,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | 450,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 450,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 324,246,200.00 | 406,324,400.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 297,818,700.00 | 370,214,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 297,818,700.00 | 370,214,300.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 26,427,500.00 | 36,110,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 26,427,500.00 | 36,110,100.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 271,676,816.45 | 406,050,507.56 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 271,676,816.45 | 406,050,507.56 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 271,624,496.79 | 403,853,185.71 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 184,491,225.35 | 286,918,037.10 |
| 210101 | Үндсэн цалин | 137,719,380.28 | 184,895,865.99 |
| 210102 | Нэмэгдэл | 40,260,162.49 | 90,980,577.35 |
| 210104 | Урамшуулал | 6,511,682.58 | 11,041,593.76 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 23,659,181.07 | 35,303,963.46 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 16,249,470.70 | 24,688,298.75 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,930,585.16 | 2,695,630.09 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,489,699.53 | 1,447,409.12 |
| 210204 | Ажил үйлдлийн даатгал | 361,403.95 | 1,220,766.60 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,628,021.73 | 5,251,858.90 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 24,975,180.34 | 31,912,778.15 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,478,168.30 | 4,214,098.15 |
| 210302 | Түлш, халаалт | 20,348,000.00 | 26,315,680.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,149,012.04 | 1,383,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 29,065,750.00 | 34,465,750.00 |
| 210502 | Хоол, хунс | 29,065,750.00 | 34,465,750.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,400,000.00 | 2,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,400,000.00 | 2,000,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 539,000.00 | 1,121,900.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 539,000.00 | 1,121,900.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,494,160.03 | 12,130,757.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 5,874,660.03 | 8,648,757.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,619,500.00 | 3,482,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 52,319.66 | 2,197,321.85 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 52,319.66 | 2,197,321.85 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 52,319.66 | 2,197,321.85 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 52,569,383.55 | 723,892.44 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 499,990.00 | - |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 499,990.00 | - |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 499,990.00 | - |
| 223001 | Бусад хөрөнгө | 499,990.00 | - |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (499,990.00) | - |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 52,069,393.55 | 723,892.44 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 55,216,593.31 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 55,216,593.31 | 55,940,485.75 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|---|------------------------------------|--------------------------|----------------------|--|
| D01 | 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 27,787,083.00 | 36,673,682.52 | 525,183,607.29 | 589,644,372.81 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 27,787,083.00 | 36,673,682.52 | 525,183,607.29 | 589,644,372.81 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (5,210,902.07) | (5,210,902.07) |
| D09 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 27,787,083.00 | 36,673,682.52 | 519,972,705.22 | 584,433,470.74 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|-----------------------|--|-----------------------|-----------------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 462,055,200.00 | 403,853,185.71 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 462,055,200.00 | 403,853,185.71 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 462,055,200.00 | 403,853,185.71 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 335,737,800.00 | 286,918,037.10 |
| 210101 | Үндсэн цалин | 228,868,800.00 | 184,895,865.99 |
| 210102 | Нэмэгдэл | 103,411,900.00 | 90,980,577.35 |
| 210104 | Урамшуулал | 3,457,100.00 | 11,041,593.76 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 39,129,900.00 | 35,303,963.46 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,609,000.00 | 24,688,298.75 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,129,700.00 | 2,695,630.09 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,565,200.00 | 1,447,409.12 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,565,200.00 | 1,220,766.60 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,260,800.00 | 5,251,858.90 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 34,110,100.00 | 31,912,778.15 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,402,300.00 | 4,214,098.15 |
| 210302 | Түлц, халаалт | 26,357,800.00 | 26,315,680.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,350,000.00 | 1,383,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 36,243,800.00 | 34,465,750.00 |
| 210502 | Хоол, хүнс | 36,243,800.00 | 34,465,750.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,122,200.00 | 1,121,900.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,122,200.00 | 1,121,900.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,711,400.00 | 12,130,757.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,229,400.00 | 8,648,757.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,482,000.00 | 3,482,000.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 462,055,200.00 | 404,577,078.15 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 370,214,300.00 | 370,214,300.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 370,214,300.00 | 370,214,300.00 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 36,110,100.00 | 33,912,778.15 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 36,110,100.00 | 33,912,778.15 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 55,730,800.00 | 450,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 520,000.00 | 450,000.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 55,210,800.00 | |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 55,216,593.31 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 55,940,485.75 |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | - | 1 |
| 610001 | Төсвийн байгууллага | | 1 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 13 | 13 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 6 | 6 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 6 | 6 |

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 3,720.5 мянган төгрөгийн 3 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залрууллаа. Үүнд:

- Санхүүгийн үр дүнгийн тайланд цалингийн зардлыг анхан шатны баримтаас 843.5 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн.
- Ажиллагсадаас суутгасан ХХОАТ-ын 679.6 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн боловч санхүүгийн бүртгэл тайланд авлагаар бүртгээгүй.
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төсөв 58,411.3 мянган төгрөгөөр зөрүүтэй, төсөвт төвлөрүүлсэн 2,197.3 мянган төгрөгийг тохируулаагүй байна.

Аудитаар 5,897.6 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд 1 төлбөрийн акт, 1 албан шаардлага хүргүүлэв.

3.1 Төлбөрийн акт

1. Хүнсний материалын үлдэгдэлд түүвэр тооллого хийхэд 5,487.5 мянган төгрөгийн 439 кг мах дутагдсан. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 73.2 дахь заалтыг зөрчсөн байна.

3.2 Албан шаардлага

Санхүүгийн тайланд тусгагдсан татварын 215.0 мянган төгрөг, нийгмийн даатгалын 195.1 мянган төгрөг буюу нийт 410.1 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5. "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.3 Зөвлөмж

Байхгүй.

4 АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|--|------------|----------------|-----------------------------------|--------------|--------------------------|----------------|------------|----------------|--------------|-----|---------|-----|
| | | | | | | | Запруулсан | | Запруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн үр дүнгийн тайланг буруу тайлагнасан. | 1 | 843.6 | | | 1 | 843.6 | 1 | 843.6 | | | | |
| Илүү шилжүүлсэн ХХОАТ-ыг авлагаар бүртгээгүй | 1 | 679.6 | 1 | 679.6 | | | 1 | 679.6 | | | | |
| Төсвийн гүйцэтгэлийн тайланд тохируулга хийгээгүй. | 1 | 2,197.3 | | | 1 | 2,197.3 | 1 | 2,197.3 | | | | |
| Дүн | 3 | 3,720.5 | 1 | 679.6 | 2 | 3,040.9 | 3 | 3,720.5 | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Үүнээс | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|--|-------------|----------------|---------------|----------------|-----------------|--------------|---------|-----|--------------------------------------|---------------------|---|-----|
| | | | | | | | Зөвлөмж | | | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Бараа материал дутагдсан | 1 | 5,487.5 | 1 | 5,487.5 | | | | | | | | |
| Татварын 215.0 мянган төгрөг, НД-ын 195.1 мянган төгрөг буюу нийт 410.1 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй | 1 | 410.1 | | | 1 | 410.1 | | | | | | |
| Дүн | 1 | 5,897.6 | 1 | 5,487.5 | 1 | 410.1 | | | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|--|-------------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |


**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ**

2025 оны 02 сарын 19 өдөр

Дугаар 57-ХЭА-2025/076/НА-СТА-ТШЗ Чингис хот
17925043

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Мөрөн сумын Цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын 2024 оны жилийн эцсийн үлдэгдлийг тулган баталгаажуулах горим сорилыг хэрэгжүүлэх хүрээнд хүнсний материалын үлдэгдэлд түүвэр тооллогыг хийхэд 439 кг буюу 5,487.5 мянган төгрөгийн мах дутагдаж, жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг чанартай, үнэн зөв явуулаагүй, санхүүгийн тайланд үлдэгдлийг зөв тусгаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 2-т "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана.", гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.7.-д "Төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг дутаасан, үрэгдүүлсэн, хууль бусаар ашигласан" гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Тооллогоор дутагдсан 439 кг махны үнэ 5,487.5 төгрөгийг Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого"-ын 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Мөрөн сумын Цэцэрлэгийн эрхлэгч Д.Пүрэвжаргал, нягтлан бодогч Ц.Уугантуяа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Б.НАРАНЦЭЦЭГ



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 дугаар сарын 20

Дугаар 78-ХЭА-2025/076/НА-СТА-ТШЗ
17925043 Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Мөрөн сумын Цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн тайланд тусгагдсан татварын 215.0 мянган төгрөг, нийгмийн даатгалын 195.1 мянган төгрөг, нийт 410.1 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5. "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7-д "Авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулдаггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мөрөн сумын Цэцэрлэгийн эрхлэгч Д.Пүрэвжаргал, нягтлан бодогч Ц.Уугантуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

"СТАНДАРТ ДҮГНЭЛТ АУДИТ"
ХХК-ИЙН АУДИТОР

Б.НАРАНЦЭЦЭГ

232504078